

- ⁵ Правда. 1988.7.31
⁶ Баньюэ Тан. 1987. No 1., 33-р тал
⁷ Гуанминь жибао. 1987.2.23
⁸ Бээжин ревью. 1987. No 3., 21-р тал
⁹ Жэньминь жибао. 1985.5.11
¹⁰ Хуньци. 1982., No 10, 30--31-р тал
¹¹ Хятадын тоо бүртгэлийн түүвэр., Бээжин., 1986., 124, 223-р тал
¹² Жэньминь жибао. 1988. 11.26.
¹³ ХКН-ын ХП их хурал. Бээжин ., 1982
¹⁴ Жэньминь жибао., 1989.11.12
¹⁵ Реформа хозяйственной системы в КНР. Москва., 1989

АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ ДАХЬ АНУ-ЫН БОДЛОГО: ЗАЛГАМЖ ЧАНАР, ШИНЭ ЗҮЙЛ

Х. Хулан

Ази-Номхон далайн бүс нутаг (АНДБН) дахь АНУ-ын бодлого, нөлөө нь түүний газарзүй, стратегийн байдал, хүчин чадлаараа уг бүс нутгийн олон улсын улс төр, эдийн засгийн бүтцэд гол байр суурь эзэлдэгээр тодорхойлогдоно. Америкийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг бол дэлхий дахиныг хамарсан стратегийн элемент, бүс нутаг дахь гол төлөв улс төр, эдийн засгийн сонирхол, улс орнуудтай байгуулсан хоёр талын харилцаа юм. Гэхдээ АНУ-ын бодлого энэхүү хэсгүүдийн жирийн нийлбэр төдий биш, харин бүс нутаг дахь улс төрийн нэгдмэл гадаад стратеги билээ. Энэ стратеги нь эрчимтэй хөгжиж, дэлхий дахины бодлогод нэн чухал ач холбогдолтой болж байгаа бүс нутагт АНУ-ын цэрэг улс-төрийн болон эдийн засгийн нөлөөг бэхжүүлэх зорилго агуулж байна.

АНУ-ын стратегийг тодорхойлоход ач холбогдолтой АНДБН-ийн олон улсын харилцааны үндсэн хандлага ямар болохыг цэгнэж үзэхийг оролдъё. Нэгдүгээрт, АНДБН-ийн гол гол улсуудын хоорондын харилцаа шилжилтийн урсгал байдалтай бөгөөд холбоотны тодорхой бүтэц тогтоогүй байна. Ийм тодорхой биш байдалтай боловч бүс нутагт цэрэг-улс төрийн болон үзэл суртлын хурцадмал байдал намжих үндсэн хандлагатай. Үүнд тус дөхөм болж байгаа нэгэн хүчин зүйл бол АНУ, ЗХУ, Хятад, Япон зэрэг эндэхийн гол орнуудад эдийн засаг, нийгмийн хувьд шинэчлэл гүнзгийрч, зарим талаар бүтцийн чанартай болж байна. Иймээс тэд эд материалын ихээхэн зардал, цэрэг улс төрийн осолтой үйлдэг шаардахгүй. хянамгай бодлого явуулах хэрэгцээтэй тулгарч байна.¹

Бүтцийн шинж бүхий бас нэг хандлага гэвэл аж үйлдвэрийн шинэ орнууд эдийн засгийн талаар өрнүүн өсч, худалдааны чиг шугам өөрчлөгдөн, цахим хүчний болон дэд бүтцийн цоо шинэ салбарууд асар их хөгжиж байгаагийн улмаас бүс нутгийн орнууд Номхон далай даяар харилцан үйлчлэх болов. Ингэж үйлчлэхэд бүс нутгийн орнуудын харилцаа «азичлагдаж», уг бүсээс гадуур оршдог гүрнүүдийг түшиглэж

байсан өмнөх үеийнхтэй харьцуулбал бүс нутаг дотроо хамтын ажиллагаагаа илүү хөгжүүлж байгаа байдал чухал нөлөө үзүүлж байна. Одоо бүс нутгархах бүтэц бүрэлдэж байгаа нь ч үүнтэй холбоотой. Ийм нутгархах хандлагын үндэс агуулгыг цэргийн биш, харин улс төр эдийн засгийн хүчин зүйлүүд тодорхойлж байна. Гэхдээ энэ бүхэн нь бүс нутгийн аюулгүй байдал, гол гол орнуудын цэргийн бодлоготой шууд холбоотой. АНДБН дахь АНУ-ын бодлогыг авч үзвэл, америкийн улс төрийн бодлоготон үр ашигтай аюулгүй байдлыг хангах асуудалд зарим талаар шинээр хандаж, ийм байдлыг хангах талаар бүс нутгийн олон улсын харилцаанд оролцогчид нийтээрээ хариуцлага хүлээж, эдийн засаг, нийгэм, улс төрийн мөн цэргийн хүчин зүйлд тулгуурлах ёстой гэж үзэх болов.

Одоо практик дээр бүс нутаг дахь АНУ-ын цэргийн бодлого нь АНУ-ын цэрэг-усан цэргийн яамны сайд Джон Леманы 1984 оны 8-р сарын 31-нд зарласан «далайн стратег»-ийг залгамжлан үргэлжлүүлж байна. АНУ-ын «далайн стратеги» буюу өөрөөр хэлбэл «далайн хүчнийг тэргүүн эгнээнд байрлуулах стратеги» нь АНДБН дахь цэргийн хүчний тэнцвэрт сүрхий нөлөөлсөн юм. Энэ стратеги бол АНУ далайн цэргийн давамгайл байдлаа Зөвлөлтийн хуурай цэргийн хүчнийг тогтооход ашиглах хэрэгсэл болж байв. Ингэснээр «ЗХУ-ын далайн цэргийн хүчнийг нэгэн бүс нутгаас нөгөө рүү шилжүүлэхийг зогсоох»-ын² тулд Европт болсон будлианыг АНДБН-т даруй шатлан дамжуулж өргөтгөх зорилготой юм. Европ буюу Алс Дорнодод үүссэн цэргийн мөргөлдөөнийг дэлхий нийтийн будлиан болгон шатлан өргөтгөх нь АНУ-ын «далайн стратег»-ийн гол чиглэл байх ёстой гэж үзжээ. Хэрэв Қартерын «дүүжингийн стратеги» гэгч нь Европ болон Алс Дорнодыг стратегийн хувьд хуваагдмал байлгахтай холбоотой цогцолбор асуудлыг шийдвэрлэх оролдлого байсан бол «далайн стратеги» АНУ ын цэрэг дайны ажиллагааг Европ, Алс Дорнодод нэгэн зэрэг явуулах чадвартай гэдэгт үндэслэж байна. Чухамдаа болзошгүй цэргийн мөргөлдөөний өөр өөр нутаг дэвсгэрийн стратегийн бие даасан байдал нэмэгдэх нөхцөлд АНДБН-ийн ач холбогдол өссөнийг АНУ хүлээн зөвшөөрснийг уг стратеги илэрхийлжээ.³

АНДБН дахь АНУ-ын стратегийн гол холбоотон бол Япон юм. «Далайн стратеги»-ийг хэрэгжүүлэхийн тулд АНУ, Японтой цэргийн хамтын ажиллагаагаа улам нягт болгох шаардлагатай. Онцгой нөхцөлд Япон нь Номхон далайн усан хоолойг бүслэн хамгаалж, нөгөө талын усан доогуур шумбагч онгоц болон бөмбөгдөгч нисэх онгоцны эсрэг дайнд оролцох ёстой, Рейганы засаг захиргааны үед Япон хоёр талын стратегийн хамтын ажиллагааны талаар зарим буулт хийснийг 1995 оны 9-р сард албан ёсоор гарын үсэг зурсан батлан хамгаалалтын 5-р төлөвлөгөөнд тусгасан билээ. Түүнчлэн АНУ нь Өмнөд Солонгос, Австрали зэрэг бусад холбоотонтойгоо харилцахдаа ч хамтын батлан хамгаалалтад оруулах хувь нэмрээ нэмэгдүүлж, мөн дэд ерөнхийлөгч Куэйл 1989 оны 5-р сард Сингапурт хэлснээр «холбоотны харилцаа нь цэргийн хүчнээр хязгаарлахгүй, нийтийн улс төрийн зорилгод ч үндэслэх ёстой»-г харгалзвал зохино гэж сануулсан юм⁴. Дэлхий дахины олон улсын байдал нааштай өөрчлөгдөж, Зөвлөлт-америкийн харилцаа зөөлрөхийн хамт АНДБН болон дэлхий нийтэд АНУ ын цэргийн стратеги ямар үүрэг, бүтэцтэй байх вэ, түүнийг яаж төлөвлөх вэ гэдэг асуудлаар америкийн эрдэмтдийн дунд маргаан үүсч байна. Тухайлбал АНУ ойрын үед тэргүүн эгнээний хүчээ, үүний дотор цэргийн баазаа хорогдуулбал зохино гэж америкийн томоохон судлаач Р. Скалапино үзэж байна⁵. Хэрэв тэгвэл уг нутаг дахь АНУ ын холбоотны харилцааны системийг эрс өөрөөр дүгнэж үзэх ёстой.

«Номхон далайн хамтын ажиллагаа»-ны асуудлаар АНУ-ын бодлого илт идэвхжиж байна. «Номхон далайн хамтын ажиллагаа»-ны үзэл санааг 70-аад оны үеэр АНУ-д төдий л таашааж үзэхгүй байсан билээ. Харин 80-аад оны эхний хагаст байдал эрс өөрчлөгдөв. Ерөнхийлөгч асан Рейган Японы парламентад 1983 оны 11-р сард хэлсэн үгэн дээ «Номхон далайн давалгаа»-ны үзэл баримтлалыг зарласан билээ. Энэ баримтлалын дагуу Номхон далайн бүс нутагт бүрэлдэж байгаа хамтын нийгэмлэгт илүү идэвхтэй оролцож, уг нутгийн орнуудын эдийн засгийн харилцааг онцгойлон үзэх ёстой гэдгийг тодорхойлсон юм. АНУ-ын шинэ засаг захиргаа тогтсон эхний 100 хоногийн дотор ерөнхийлөгч Буш, дэд ерөнхийлөгч Куэйл нарын Зүүн Азид хийсэн айлчлалт нь америкийн улс төрийн бодлоготны зүгээс дэлхийн улс төрийн бодлогын шинэ төвийг ихэд сонирхож байгааг харуулав. Энэ бүс нутгийн орнуудтай АНУ-ын эдийн засгийн харилцаа дорвитой ахиж байгаа нь уг сонирхолын шалтгаан болж байна. 1983 онд АНУ, Зүүн Азийн худалдааны хэмжээ АНУ, Баруун Европын худалдааг давлаа. Зүүн Азийн орнуудтай хийдэг худалдаа 1987 ОНД АНУ-ын Олон улсын Нийт худалдааны 35 хувийг эзлэв. Үүний хамт эдгээр орнуудын хувьд АНУ-ын худалдааны алдагдал 107 тэрбум доллар хүрсэн нь АНУ-ын худалдааны нийт алдагдлын 60 хувь болж байна.⁶ АНУ-д энэ бүсийн харилцан уялдааны үзэл баримтлалыг улам бүр анхаарч, «Номхон далайн харилцан үйлчилгээ»-нд оролцогсдын стратегийн болон эдийн засаг, улс төрийн ашиг сонирхолыг уялдуулан үзэх болов⁷. Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал, Номхон далайн сав газрын эдийн засгийн зөвлөлөөс гадна Номхон далайн өөр шинэ байгууллага бий болгохыг америкийн нэлээд хэдэн улс төрийн бодлоготон уриалж байна. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Дж. Бейкер 1989 оны зун Зүүн Азид хийсэн айлчлалынхаа үеэр «Номхон далайд шинэ байдлаар хамтарч ажиллах» үзэл санаа нь юуны өмнө бүс нутагт АНУ-ын тэргүүлэх үүргийг бэхжүүлэхэд чиглэж байна. Энэ бол ингэж тэргүүлэх зорилго бүхий Японтой өрсөлдөж байгаагийн нэгэн шинж тэмдэг мөн. Эйша Сосайетид 1989 оны 6-р сарын 26-нд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Дж. Бейкерийн хэлсэн үгэнд илэрхийлсэн америкийн үзэл баримтлалын хоёрдугаар асуудал бол АНУ, Японы «нийтийн хамтын ажиллагаа»-г тогтоох эрмэлзэл юм. Үүнд Японы төсөвт цэргийн зардлын хувь өсч, тус оронд байрласан америкийн цэргийн зардлын 40 хувийг дааж, хоёр орон цэргийн шинэ шинэ техник боловсруулах, тухайлбал FSX бөмбөгдөгч нисэх онгоц үйлдвэрлэх талаар хамтран ажиллах, «гуравдахь ертөнц»-ийн орнуудад эдийн засгийн тусламж үзүүлэх төсөл хэрэгжүүлэхэд Японы Үүрэг нэмэгдэж, санхүүгийн өрийн асуудлыг шийдвэрлэхэд Японы засгийн газар оролцох саналтай байгаа зэрэг нь дээрх эрмэлзлийг хангах хүчин зүйл болж байна⁸. Япон өөрийнхөө гадаад бодлогод эдийн засаг, улс төр, цэргийн хэрэгслийн харьцааг өөрчлөн хянаж үзэх ёс той гэж АНУ-ын засаг захиргаа үзэж байна. Америкийн улс төрийн бодлоготнууд Японтой худалдааны талаар ноцтой зөрчилтэй байгаагаа зохицуулахыг хоёр орны стратегийн хамтын ажиллагааны асуудалтай холбон үзэж байна. Америкийн дээр дурьдсан төлөвлөгөөний гурав дахь асуудал бол бүс нутаг дахь бодлогыг идэвхжүүлэх асуудал юм. Бүс нутгийн дотоод худалдааны хэмжээ 1988 онд 200 тэрбум, доллар хүрч, Номхон далайн сав газарт ойртож нягтрах үйл явц түргэн хурдацтай байгааг харууллаа. Харин Өрнөд Европтой харьцуулахад өсч байгаа харилцан хамаарлыг зохицуулах механизм энд байхгүй байгаа юм. Бүс нутгийн тийм зохимжтой механизмын загварыг

зах зээлийн эдийн засаг бүхий орнуудын нэгэнт тогтсон байдлын үнд сэндээр бий болгохыг АНУ санал болгож байна. АНУ-ын эдийн засгийн нөлөө харьцангуй суларсныг америкийн засаг захиргаа хүлээж, «хариуцлагыг бүтээлчээр хуваалцах» үзэл санааг дэвшүүлэв. Номхон далайн хамтын нийгэмлэг нийгэм-эдийн засгийн янз бүрийн систем, хөгжлийн янз бүрийн түвшинтэй орнуудыг багтаахыг америкийнхан хүлээн зөвшөөрч байгаа нь урагшлах Нэгэн алхам мөн гэж бид үзэж байна⁹. Австралийн ерөнхий сайд Р. Хоук Ази-Номхон далайн эдийн засгийн чуулга (АРЕС) байгуулах тухай Сеул хотноо 1989 оны 1-р сард дэвшүүлсэн санаачлагыг АНУ дэмжив.¹⁰ Бүс нутгийн эдийн засгийн ойртож нягтрах. АРЕС-г байгуулах асуудлыг хэлэлцэхийн тулд 1989 оны 11-р сарын 5—7-нд Канберра хотноо АСЕАН-ы 6 орон, мөн АНУ, Япон, Канад, Өмнөд Солонгос, Шинэ Зеланд, Австрали нийтдээ 12 орны төлөөлөгчид цугларсан билээ. Эдгээр орны гадаад хэрэг, эдийн засгийн асуудал эрхэлсэн сайд нар ГАТТ-ын хүрээнд Уругвайд хийсэн хэлэлцээ болон бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалт, технологийн солилцооны хороодыг зохион байгуулж, мэдээллийн хамтар сан сүлжээ бий болгох талаар анх удаа нэгдмэл байр сууриа тодорхойлсон юм. АРЕС-ийн хүрээний дараагийн уулзалтыг 1990 онд Сингапурт, 1991 онд Сеулд хийхээр шийдвэрлэсэн байна¹¹. Иймд АРЕС-г байгуулсан явдал бол Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, улс төрийн үйл явцын зүй ёсны үр дүн, түүнд АНУ оролцсон нь бүс нутгийн асуудлаар шинэ байр эзэлснийх нь нотолгоо болов.

АНДБН-үйн олон улсын бодлогод оролцогч Япон, Хятад, Өмнөд Солонгос, АСЕАН-ы орнууд, Австрали, Шинэ Зеланди зэрэг улстай хоёр талын харилцаагаа хөгжүүлэхийг АНУ онцгойлон анхаарч байна. Эдгээр харилцаанд АНУ хэрхэн хандаж байгааг ерөнхийд нь товчхон тодорхойлъё.

АНУ-Япон. Японтой харилцахдаа хоёр орны эдийн засгийн хөгжил, аюулгүйн байдлын асуудлыг харгалзаж бие биетэйгээ идэвхтэй хамтран ажиллахгүйгээр аль аль нь одоо оршин тогтнож чадахгүйг үндэс болгож байна.¹² Хоёр орон бие биеэсээ ихээхэн хамааралтай, бүс нутаг дахь улс төрийн зорилго нь нийтлэг боловч худалдаа, цэргийн хамтын ажиллагааны талаар нарийн түвэгтэй зөрчилтэй. Юу нь өмнө АНУ худалдааны талаар Японтой алдагдалтай учраас барааны болон хөрөнгө оруулалтын дотоод зах зээлээ чөлөөтэй болгож» Нээхийг Японоос шаардаж байна. Эдийн засгийн зөрчлийн улмаас АНУ-д өөрийгөө хамгаалах хандлага урьд үзэгдээгүй хэмжээгээр өссөн нь америкийн үндсэрхэх үзлийн нэгэн илрэл юм гэж Р. Скалапино 1986 онд бичжээ.¹³ Гэвч удаан хугацааны турш үргэлжилсэн хэлэлцээний дараа Япон 1986 онд эдийн засгийн өсөлтдөө түлхэц өгөхийн тулд экспортын стратегийн үүргийг бууруулах, дотоод зах зээл, аж үйлдвэрийн барааны импортыг нэмэгдүүлэх, олон улсын тусламжийн хөтөлбөрөө өргөтгөх зорилгоор эдийн засагтаа нэлээд өөрчлөлт хийх тухай шийдвэр гаргасан билээ. Японоос зах зээлээ чөлөөтэй болгох, нены ханшийг нэмэгдүүлэх талаар сүүлийн үед арга хэмжээ авч, АНУ төсвийнхөө алдагдлыг багасгахаар шийдвэрлэсэн нь энэ талаар амсрик-японы зөрчлийг харьцангуй сулруулав. Хоёр орны цэргийн хамтын ажиллагааны үндсэн асуудал бол хамтын батлан хамгаалалтын зардлыг хуваалцах асуудал юм. Энэ асуудал нь Япон, АНУ-ын олон улсын тавцан дахь үүргийг хуваарилах, Японы батлан хамгаалалтын үзэл баримтлалын шинж чанарыг тодорхойлох, мөн америкийн эрдэмтэн Чалмерс Жонсоны нэрлэснээр «ноёрхлыг тогтворжуулах» онол гэгчийн хүрээний зөрчлийн асуудлыг өргөн дэлгэр болгож тавых асуудалтай холбоотой.¹⁴

АНДБН-т бий болсон хандлага Бушийн засаг захиргааны өмнө нарийн түвэгтэй асуудал тавьжээ. Эдгээр асуудалд хэрхэн хандахаа Буш, Куэйл, Бейкер нар Зүүн Азийн орнуудаар хийсэн айлчлалынхаа үеэр хэлсэн үгэндээ тодорхойлж эхлэв. Тус бүс нутгийн эдийн засгийн түргэн өсөлт, улс төрийн зөөлрөх үйл явц, үзэл суртлын эсрэг тэсрэг байдлын бууралт нь АНУ-аас стратегийн байр сууриа хянаж үзэх, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлийг уян ашиглах, олон улсын харилцаанд эсрэг тэсрэг зогсохын оронд бодитой хамтын ажиллагаа ны чиг баримтлахыг шаардаж байна.

¹Ихээхэн зардал шаардахгүй хянамгай гадаад бодлогын тухай vide Scalapino R., Key Trends in the Pacific-Asian Region, Paper presented at the Second US-Mongolia Bilateral Conference, Ulaanbaatar, June 6—8, 1988, p. 1

² Admiral James Watkins, "The Maritime Strategy". US Naval Institute Proceedings, January 1986. vide Buszynski Leszek, International Linkages and Regional Interests in Soviet Asia-Pacific Policy-Pacific Affairs, vol 61, no. 2, Summer 1988, p. 216.

³ Buszynski Leszek, op. cit., p. 216.

⁴ Vice-President Quayle. American Leadership in the Pacific. An Address before the American Business Council, Singapore, May 3, 1989. LUS Department of State, Bureau of Public Affairs, Washington D.C. Current Policy N 1173, p.3

⁵ Scalapino R. The United States and Northeast Asia. Prepared as Background for the Visit of President Bush to Asia, The Asia Society. s Media Relations Program, N. Y., February 1989. p. 16.

⁶ East Asia and the US: An Economic Partnership. East Asia and the Pacific: Regional Brief, US Department of State, Bureau of Public Affairs, Washington D. C. January 1989, p. 1.

⁷ Tbidem, p. 7.

⁸ Secretary Baker. A New Pacific Partnership: Framework for the Future. -US Department of State, Bureau of Public Affairs, Washington D. S. -Current Policy N 1185, p. 2.

⁹ Ibidem.

¹⁰ Ibidem.

¹¹ Jacqueline Rees. First Step Taken.-FEER, 16 November, 1989, vol. 146. N 46.

¹² Mansfield M. The US and Japan: Sharing Our Destinies-Foreign Affairs, vol. 68, N 2, Spring 1989, p. 3

¹³ Scalapino R. The United States and the Security of Asia. -in: Internal and External Security Issues in Asia. University of California, Berkeley, 1986, p.71.

¹⁴ Jolinson Ch. The End of American Hegemony and the Future of Japanese American Relations. Paper presented at the Second US-Mongolia Bilateral Conference, Ulaanbaatar, June 6--8, 1988, p. 1-6.

¹⁵ vide Lord W. China and America: Beyond the Big Chill. -Foreign Affairs, titumn 1989, vol. 68, N 4, p. 20.

¹⁶ Ibidem.

¹⁷ Delis Robert Nixon Warns Cliina's Leaders over Split with West. -FEER, November 16, 1989. vol. 146, N 46, p. 20-21.

¹⁸ Чан Юн Бан. Сеул- Москва: Экономические связи н безопасность. Проблемы Дальнего Востока, 1989, No 5, с. 84.

¹⁹ Scalapino. The United States and Northeast Asia....p. 34-35.